



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

Либертари нам (ЛН) үүсгэн байгуулагдсан
болон намын дарга сонгогдсоныг
бүртгэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Д.Батбаатар, Н.Батзориг, М.Батсуурь, Б.Батцэрэн, Н.Батчимэг, Н.Баярмаа, Э.Золзаяа, Ц.Оч, М.Пүрэвсүрэн, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Б.Ундрах, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Либертари нам (ЛН) үүсгэн байгуулагдсан болон намын даргаар Э.Оргил-Эрдэнэ сонгогдсоныг бүртгүүлэх тухай өргөдлийг шүүгч П.Соёл-Эрдэнийн танилцуулснаар хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Либертари нам (ЛН)-ын даргаар сонгогдсон Э.Оргил-Эрдэнээс 2026 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр “... Либертари намыг шинээр үүсгэн байгуулсан болохыг улсын бүртгэлд бүртгүүлэхээр дахин хандаж байгаа тул хүлээн авч бүртгэж өгнө үү” гэсэн өргөдлийг нийт 1995 хуудас баримт (8 хавтас), 1 ширхэг флашны хамт Улсын дээд шүүхэд ирүүлсэн.

2026 оны 02 дугаар сарын 16-ны өдөр “Либертари намыг үүсгэн байгуулах Их хурлаар Э.Оргил-Эрдэнэ намайг намын даргаар сонгосон тул бүртгэж өгнө үү” гэсэн өргөдлийг 124 хуудас баримтын хамт, мөн 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдөр 53 хуудас баримт болон цахим шуудангаар 92 хуудас цахим баримтыг тус тус нэмэлтээр ирүүлсэн.

ҮНДЭСЛЭХ нь:

Либертари нам (ЛН)-ыг үүсгэн байгуулах Их хурлыг 2025 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр танхимын хэлбэрээр зохион байгуулж, тус намын даргаар сонгогдсон Э.Оргил-Эрдэнээс 2026 оны 10 дугаар сарын 08-ны өдөр нам үүсгэн байгуулагдсаныг бүртгүүлэх өргөдлийг Улсын дээд шүүхэд гаргасан боловч “намын гишүүнчлэлийн бодит байдал болон баримт нотолгооны агуулгад хамаарах зөрчилтэй, намын дүрмээр зайлшгүй зохицуулах асуудлыг орхигдуулсан” гэсэн үндэслэлээр Улсын дээд шүүхийн 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 02/3690 дугаартай албан бичгээр тус өргөдлийг буцааж, илэрсэн зөрчлүүдийг бүрэн арилгасны дараа бүртгүүлэх өргөдөл гаргах боломжтойг мэдэгдсэн байна.

Намын даргаар сонгогдсон Э.Оргил-Эрдэнээс 2026 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр намыг шинээр үүсгэн байгуулагдсаныг бүртгүүлэх өргөдлийг Улсын дээд шүүхэд дахин гаргасан нь Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Намыг зохион байгуулах Их Хурал /цаашид “үүсгэн байгуулах хурал” гэх/-аар үүсгэн байгуулна”, 12 дугаар зүйлийн 12.1-д “Энэ хуулийн 11.4.4-т заасан намын даргаар сонгогдсон гишүүн, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч нам үүсгэн байгуулагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор намыг бүртгүүлэх өргөдлийг энэ хуулийн 12.3-т заасан баримт бичгийн хамт Улсын дээд шүүхэд бичгээр хүргүүлнэ” гэж заасанд нийцсэн, өргөдөл, түүнд хавсаргасан баримт нь тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 12.3-т заасан бүрдлийн шаардлагыг хангасан байна.

Либертари нам (ЛН) нь 2025 оны 09 дүгээр сарын 19, 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр тус тус “Либертари нам (ЛН)” гэсэн нэрийн баталгаажуулалтыг Улсын дээд шүүхийн Тамгын газраас авсан бөгөөд 2026 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийг хүртэл сунгасан байна. Тус намын оноосон бүтэн нэр нь “Либертари нам”, англиар “Libertarian Party” гэх бөгөөд нэрийг кириллээр “ЛН”, латинаар “LP” гэж тус тус товчилж хэрэглэхээр намын үндсэн дүрэмд заажээ. Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Нам нь оноосон нэртэй байх бөгөөд түүний төгсгөлд “нам” гэсэн ерөнхий нэрийг заавал хэрэглэнэ”, 6.4-т “намын бүтэн болон товчилсон нэр, бэлгэ тэмдэг нь төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, сүм хийд, өөр хуулийн этгээд, бусад намын нэр, бэлгэ тэмдэгтэй давхардсан буюу бусдыг төөрөгдүүлэхээр ижил, төсөөтэй байж болохгүй” гэж хуульчилсан. Либертари нам (ЛН)-ын бүтэн болон товчилсон нэрийн хувьд өөр бусад хуулийн этгээдийн нэртэй давхардсан, бусдыг төөрөгдүүлэхээр төсөөтэй гэх нөхцөл тогтоогдоогүй болно.

Нэг. Үүсгэн байгуулах Их хурлын тухайд:

Либертари нам (ЛН)-ын Ажлын хэсгээс 2025 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн №143(7755) дугаартай Өдрийн сонинд, мөн өдрийн №147(7644) дугаартай Зууны мэдээ сонинд тус тус “Либертари намын гишүүдийн анхааралд: Либертари намыг үүсгэн байгуулах Их хурлыг 2025 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 10:00 цагт Сүхбаатар дүүргийн 1-р хороо, Олимпик резиденс, 22-1 тоотод байрлах “NAPA BISTRO”-д хийх тул гишүүд өргөнөөр идэвхтэй оролцоно уу” гэж нийтэд мэдээлсэн; мөн 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдөр Либертари нам (ЛН)-ын гишүүдээс 678 гишүүнд цахим шуудангаар үүсгэн байгуулах Их хурал хаана, хэзээ хуралдах зарыг хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэх асуудлын жагсаалтын хамт хүргүүлсэн байна.

Ийнхүү намыг үүсгэн байгуулах Их хурлыг 2025 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр дээр дурдсан хэлбэрээр нийтэд болон гишүүдэд мэдээлснээс хойш 33 өдрийн дараа хуралдуулсан нь Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 11 дүгээр зүйлийн 11.2-т “Намыг үүсгэн байгуулах хурлын бэлтгэлийг урьдчилан хангах бөгөөд зохион байгуулах газар, хугацааг нэг сарын өмнө төлөөлөгчдөд мэдэгдсэн байна” гэж заасан хуулийн шаардлагад нийцсэн байна.

Үүсгэн байгуулах Их хуралд оролцсон Улаанбаатар хотод оршин суух хаягтай гишүүдийн ирцийн бүртгэлд нийт 94 дэс дугаараар дугаарласан жагсаалт байх боловч 18 дугаар мөрөнд гишүүн бүртгэгдээгүй, орон нутгаас ирж оролцсон бүртгэлд

9 гишүүн бүртгэгдсэн ч 5 дугаарт бүртгэгдсэн гишүүн нь Улаанбаатар хотын хаягтай байна. 2026 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр дахин гаргасан өргөдөлд “Үүсгэн байгуулах Их хурлын тэмдэглэлийг хөтөлж байсан, мөн Удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсон Т.Даариймаа төлөөлөгч Их хуралд оролцсон гишүүдийн цаасан бүртгэл дээр өөрийгөө бичиж бүртгүүлээгүй байсан тул 94 дүгээр дэс дугаарт нөхөж бүртгэн алдааг залрууллаа” гэх тайлбарыг ирүүлсэн байх ба Т.Даариймаа нь үүсгэн байгуулах Их хурлын нарийн бичгийн даргаар сонгогдож, хуралдааны тэмдэглэлийг хөтлөн гарын үсэг зурснаас гадна хуралдааны явцад биечлэн оролцож Удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсон нь Либертари нам (ЛН)-ыг үүсгэн байгуулах Их хурлын тэмдэглэл, хуралдааны видео бичлэг, фото зургаар тогтоогдож байна. Иймд, үүсгэн байгуулах Их Хуралд Улаанбаатар хотод оршин суух хаягтай нийт 94 төлөөлөгч, орон нутгаас 8 төлөөлөгч оролцсон гэж үзэхээр байна.

Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д намыг үүсгэн байгуулах Их хуралд оролцвол зохих төлөөлөгчдийн тоог хуульчлан тогтоогоогүй бөгөөд хурлын зарыг хуульд заасан хугацааны өмнө өдөр тутмын сонинд нийтлэн олон нийтэд нээлттэйгээр мэдээлсний үндсэн дээр орон нутгаас төлөөлөх төлөөллийг оролцуулан нийт 102 гишүүний оролцоотойгоор хуралдсан нь хуулийн зөрчилгүй юм.

Түүнчлэн, Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 11 дүгээр зүйлийн 11.4-т “Намыг үүсгэн байгуулах хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ”, 11.4.1-д “намын бүтэн болон товчилсон нэр, бэлгэ тэмдгийн загварыг батлах”, 11.4.2-т “намын хөтөлбөр, дүрмийг батлах”, 11.4.3-т “төлөөллийн төв, гүйцэтгэх төв болон хяналтын байгууллагын бүрэлдэхүүнийг сонгон байгуулах, түүний зохион байгуулалтын бүтэц, эрх, үүргийг тогтоох”, 11.4.4-т “намын даргыг сонгох”, 11.4.5-д “нам үүсгэн байгуулсан тухай шийдвэрийг батлах” гэж хуульчилсан.

Либертари нам (ЛН)-ын үүсгэн байгуулах Их хурлаар намын нэр, бэлгэ тэмдгийг батлах асуудлыг хэлэлцэх санал хураалтад 88 гишүүн оролцож, 03 дугаар тогтоолыг, намын үндсэн дүрмийг батлах санал хураалтад 94 гишүүн оролцож, 04 дүгээр тогтоолыг, нам үүсгэн байгуулсан тухай шийдвэрийг батлах санал хураалтад 79 гишүүн оролцож, 09 дүгээр тогтоолыг тус тус баталсан байна.

Үүсгэн байгуулах Их хурлын үйл ажиллагаа нь дэгийн дагуу явагдсан болох нь өргөдөлд баримтаар хавсарган ирүүлсэн 5 цаг 56 минутын видео бичлэгээр нотлогдож байхаас гадна үүсгэн байгуулах Их хурлаар хэлэлцэн шийдвэрлэвэл зохих асуудлыг бүрэн шийдвэрлэсэн, ийнхүү шийдвэрлэхдээ Их хурлын төлөөлөгчдийн оролцоо, ил тод байдлыг хангаж, намын бүтцийн нэгжийн сонгуульд нэр дэвшүүлэх болон сонгох санал хураалтыг хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Нам гишүүдээ намын удирдах байгууллага, албан тушаал, сонгуульд нэр дэвших, сонгох, томилоход аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байж, тэгш боломж олгоно” гэж заасан зарчим болон хуулийн 8.2-т заасан шаардлагыг хангаж явуулсан байна.

Иймд, Либертари нам (ЛН)-ын 2025 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр хуралдсан үүсгэн байгуулах Их хурлын үйл ажиллагаа нь Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нийцсэн, хурлаар шийдвэрлэвэл зохих асуудлыг бүрэн шийдвэрлэж, хурлаар хэлэлцсэн асуудлыг олонхын саналаар шийдвэрлэх ардчилсан зарчмыг болон гишүүдийн оролцоо, ил тод байдлыг хангасан байна.

Хоёр. Намын гишүүний бүртгэлийн тухайд:

Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 12 дугаар зүйлийн 12.3, 12.3.6-д зааснаар намыг бүртгүүлэх өргөдөлд “намын 801-ээс доошгүй гишүүний бүртгэл /ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, гарын үсэг/-ийг хавсарган ирүүлэхээр заасан.

Либертари нам (ЛН)-ын 2026 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн өргөдөлд хавсарган ирүүлсэн намын 801 гишүүний бүртгэлийн мэдээллийг өмнөх 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн өргөдлөөр ирүүлсэн 801 гишүүн, Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 9/12034 дугаартай албан бичгээр ирүүлсэн мэдээллийн зөрүүтэй гишүүдийн нэрстэй тулган үзэж, мэдээлэлд нь өөрчлөлт орсон (хаягийн мэдээллээс бусад) нийт 57 гишүүний мэдээллийг хууль, журамд заасан шаардлага хангасан эсэхийг захиргааны байгууллагаар шалгуулсан, тодруулбал, Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 6/902 дугаартай албан бичгээр “мэдээллийн санд шалгахад 7 иргэний хаягийн мэдээлэл зөрүүтэй” байдал тогтоогдсон байгаа боловч эдгээр иргэдийн хаягийн мэдээллийн зөрүүтэй байдлыг зөрчилд тооцохооргүй байна. Учир нь Улс төрийн намын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Улсын дээд шүүх намыг дараах үндэслэлээр намын бүртгэлд бүртгэхээс татгалзана” гээд 14.4.3-т “гишүүдийн тоо энэ хуулийн 12.3.6-д заасан тоонд хүрээгүй, бүртгэлд орсон гишүүн нь өөр намын харьяалалтай, эсхүл өөр хүн төлөөлсөн” гэж заасан татгалзах үндэслэлд дээрх иргэдийн хаягийн зөрүүтэй байдал нь шууд хамаарах, татгалзах нөхцөл биш болно.

Мөн намын гишүүний бүртгэлийн баримт болох 17 гишүүний нотломжид зөрчил илэрснийг тодруулах зорилгоор намын гишүүнээр элссэн гэх иргэдээс судалгааг авахад 6 иргэний бүртгэл зөрчилтэй байсан. Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 13 дугаар зүйлийн 13.2.3, Улс төрийн намын бүртгэл хөтлөх журмын 2.3, 2.5-д заасан хугацааны дотор намын даргаар сонгогдсон Э.Оргил-Эрдэнээс дээрх 6 гишүүнийг өөр гишүүдээр сольж, “намын гишүүдийн цаасан бүртгэлээс файл хэлбэрт оруулан хуулж бичихдээ бичиглэлийн алдаа гаргасан 12 гишүүний хувийн мэдээллийг засаж зөвтгөсөн” гэх тайлбар, гишүүдийн гарын үсэг бүхий нотломж, баримтыг намын шинэчилсэн 801 гишүүний бүртгэлийн жагсаалтын хамт ирүүлсэн. Намын гишүүнээр элссэн бүртгэлийн жагсаалтад шинээр нэмэгдсэн дээрх 6 иргэний мэдээллийг ХУР системээс болон бүртгэлийн лавлагаа мэдээлэлтэй тулган шалгахад зөрчил илрээгүй бөгөөд нотломжид илэрсэн зөрчил арилсан байна.

Тиймээс, Либертари нам (ЛН)-аас өөр намын харьяалалгүй, өөр хүнээр төлөөлүүлээгүй 801 гишүүний бүртгэлийг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан шаардлагыг ханган ирүүлсэн нь хуулийн 12 дугаар зүйлийн 12.3.6-д нийцсэн, хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.3-т заасан намын бүртгэлд бүртгэхээс татгалзах үндэслэл тогтоогдоогүй болно.

Гурав. Намын үндсэн дүрэм Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нийцсэн эсэх тухайд:

Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Намын бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог энэ хуульд заасны дагуу намын дүрмээр зохицуулна” гээд 15.2-т “Намын дүрэмд дараах нийтлэг зүйлийг тусгана.” /15.2.1-15.2.10/ гэж, 16 дугаар зүйлд намын бүтэц, зохион байгуулалтын талаар зохицуулжээ.

Тус намын үндсэн дүрэм, үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хууль, Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ болон бусад хууль тогтоомжид нийцсэн эсэхийг шалгахад зөрчилтэй байдал тогтоогдоогүй болно. Тухайлбал,

Либертари нам (ЛН)-ыг үүсгэн байгуулах Их хурлаар намын үндсэн дүрэм, хөтөлбөрийг хэлэлцэн баталж, үндсэн дүрмийн 1.1-д “Либертари нам нь хувь хүний эрх чөлөө, хувийн өмч, чөлөөт зах зээл, хязгаарлагдмал төр, нийгмийн консерватизмын үзэл санааг баримталдаг баруун жигүүрийн “палео-либертари” үзэл баримтлалтай улс төрийн байгууллага мөн”, 1.2-т “Чөлөөт зах зээлийн тогтолцоонд суурилсан, үндэсний өв уламжлалаа эрхэмлэсэн, гадны улс орнуудтай эв эетэйгээр зэрэгцэн орших нэгэн цогц хөгжлийн бодлогыг Монгол Улсад хэрэгжүүлэх нь Либертари намын зорилго мөн”, 1.5-д “Либертари намын үнэт зүйл нь хувь хүний эрх чөлөө, хувийн өмч, чөлөөт зах зээл, хязгаарлагдмал төр, нийгмийн консерватизм” гэж тодорхойлон заажээ. Энэхүү намын үзэл баримтлал, үнэт зүйл, зорилго нь Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 10 дугаар зүйлд заасан хориглосон үйл ажиллагаанд хамаарахгүй байна.

Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Нам нь удирдах дээд байгууллага, төлөөллийн төв байгууллага, гүйцэтгэх төв байгууллага, хяналтын байгууллагатай байна” гэж хуульчилсан. Либертари нам (ЛН)-ийн үндсэн дүрмийн 4.1-д зааснаар тус нам нь Удирдах дээд байгууллага, Төлөөллийн төв байгууллага, Гүйцэтгэх төв байгууллага, Хяналтын байгууллага гэсэн үндсэн бүтэцтэй байх бөгөөд намын удирдах дээд байгууллага нь Намын Их хурал, Их хурлын чөлөөт цагт ажиллах төлөөллийн төв байгууллага нь Удирдах зөвлөл, намын өдөр тутмын чиг үүргийг хариуцан ажиллах гүйцэтгэх төв байгууллага нь Гүйцэтгэх зөвлөл, намын дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих, намын дүрмээр зохицуулах дотоод маргааныг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан намын хяналтын байгууллага болох Хяналтын зөвлөлтэй байхаар зохицуулсан байна. Түүнчлэн, намын эдгээр байгууллагыг бүрдүүлэхдээ сонгуульт болон жирийн гишүүдийн оролцоо, ил тод байдал, чөлөөт өрсөлдөөний зарчмыг хангаж, нэр дэвшүүлэхэд болон бүрэлдэхүүнд байх аль нэг хүйсийн төлөөллийг хуульд заасан хувьд нийцүүлэн, нууц санал хураалтаар сонгох зарчмыг тусгасан нь Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн үзэл баримтлал, зарчим, зохицуулалтад нийцсэн гэж үзэв.

Намын үндсэн дүрмийн 4.3-т “Их хурал нь удирдах дээд байгууллага болохын хувьд дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ:” гээд Намын үндсэн дүрэм, хөтөлбөрийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, намын даргыг дөрвөн жилийн хугацаагаар сонгох, огцруулах, төлөөллийн төв байгууллага буюу Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг дөрвөн жилийн хугацаагаар сонгох, огцруулах, хяналтын байгууллага буюу зөвлөлийн бүрэлдэхүүнийг дөрвөн жилийн хугацаагаар сонгох, огцруулах, намыг өөрчлөн байгуулах, үйл ажиллагааг зогсоох,

намын нэрийг өөрчлөх зэрэг Их хурлын онцгой бүрэн эрхийг намын бусад бүтэцдээ шилжүүлээгүй, давхардуулан олгоогүй нь хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т нийцсэн байна.

Намын үндсэн дүрмийн 1.6-д намын үйл ажиллагаанд хамтын удирдлага, эв нэгдэл, дотоод ардчилалтай байх зарчмыг баримтлан намын бүх шатны байгууллага асуудлыг чөлөөтэй хэлэлцэн, цөөнхийн саналаа илэрхийлэх эрхийг хязгаарлахгүй, олонхын саналаар шийдвэрээ гаргах, нам бодлого, үйл ажиллагаандаа эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн сонирхлын бүлгүүдийн төлөөлөл, оролцоог хангаж ажиллах болон дүрмийн 1.3-т “Либертари нам нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан сахиж хуулийн хүрээнд энэхүү дүрмийг удирдлага болгон ажиллана” гэж заасан нь улс төрийн нам дотоод үйл ажиллагаандаа ардчилсан зарчмыг баримтлах, намын гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн үзэл баримтлалд нийцсэн гэж дүгнэв.

Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т “намын гишүүнээр элсэх, намын гишүүнээс түдгэлзэх, намын гишүүний эрх, үүрэг, намын гишүүнээс хасах болон бусад сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл”-ийг намын дүрэмд тусгахаар заасан. Либертари нам (ЛН)-ын үндсэн дүрмийн 3.1-д “... намын зорилго, үзэл баримтлал, намын хөтөлбөрийг хүлээн зөвшөөрч, сайн дурын үндсэн дээр намд эвлэлдэн нэгдсэн, 18 нас хүрсэн, эрх зүйн чадамжтай Монгол Улсын иргэн нь намын гишүүнээр элсэж болно”, 3.3-т “Намд гишүүнээр элсэхийг хүссэн иргэн тогтоосон маягтыг биечлэн бөглөнө. Маягтыг биечлэн бөглөх боломжгүй бол намын албан ёсны хаягаар шуудангаар эсвэл намын албан ёсны цахим хуудсаар илгээж болно” гэж заасан. Намын гишүүн өөрийн хүсэлтээр намын гишүүнчлэлээс түдгэлзэх болон өргөдөл, мэдээлэлд үндэслэн намын гишүүнээс түдгэлзүүлэх үндэслэлийг тус тус үндсэн дүрэмд тодорхойлсон байна. Мөн намын гишүүн өөрийн хүсэлтээр намаас гарах эрхийг болон намын дүрмийг зөрчсөн, намын үнэт зүйл, зарчмыг ноцтой зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй гаргасан гишүүнд сахилгын шийтгэл ногдуулах, намаас хасах асуудлыг Хяналтын зөвлөл хянан шалгаж, шийдвэрлэх хугацаа, журмыг тусгасан нь Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн зохицуулалтад нийцсэн ба иргэний намд сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхийг хангасан байна.

Либертари нам (ЛН)-ийн үндсэн дүрмийн 13 дугаар бүлэгт намын салбар болон бүтцийн нэгж байгуулах, татан буулгах үндэслэл, журмыг зохицуулж, аймаг, нийслэлийн дүүрэг, улсын зэрэглэлтэй хот болон тосгонд анхан шатны нэгж, нийслэлд дунд шатны нэгж байгуулж болох, мөн ийнхүү нэгж байгуулах гишүүдийн тоо шалгуурыг дүрэмд тусгасан ба намын анхан шатны нэгж байгуулагдаагүй тохиолдолд Төв нам нь анхан шатны нэгжийн үүрэг гүйцэтгэхээр зохицуулжээ. Анхан болон дунд шатны нэгжийн бүрэн эрхийг намын үндсэн дүрэмд тусгаж, төрийн санхүүжилтийн 16-аас доошгүй хувийг намын анхан болон дунд шатны нэгжид хуваарилахаар, намын үндсэн дүрэм, хөтөлбөрт орох өөрчлөлтийн төслийг анхан болон дунд шатны нэгжийн даргад хүргүүлж, нэгжийн дарга гишүүдэд танилцуулан, намын гишүүдийн санал, хүсэлтийг хүлээн авч, нэгтгэн Төв намд хүргүүлэхээр

заасан нь хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.10-т заасанд нийцсэн бөгөөд намын орон нутгийн төлөөллийн оролцоог намын үндсэн дүрэмд баталгаажуулсан байна.

Дөрөв. Намын даргыг сонгосон тухайд:

Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 11 дүгээр зүйлийн 11.4-т “Намыг үүсгэн байгуулах хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ”, 11.4.4-т “намын даргыг сонгох”-оор хуульчилсан.

2025 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр хуралдсан Либертари нам (ЛН)-ын үүсгэн байгуулах Их хурлаар намын даргыг сонгох сонгуульд намын гишүүн Э.Оргил-Эрдэнэ, Т.Даваажаргал нар өөрийн нэрээ дэвшүүлэн өрсөлдөж, нууц санал хураалтын дүнд тус санал хураалтад оролцсон нийт 87 гишүүнээс олонхын буюу 62 гишүүний саналыг Э.Оргил-Эрдэнэ авсан ба санал хураалт хүчин төгөлдөр явагдсаныг Либертари намыг үүсгэн байгуулах Их хурлын тооллогын комиссын 08 дугаар тогтоолоор баталж, тус санал хураалт, тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн намын даргаар Э.Оргил-Эрдэнэ сонгогдсон тухай үүсгэн байгуулах Их хурлын 08 дугаар тогтоолыг нийт 79 гишүүний ил санал хураалтаар баталсан байна.

Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Нам гишүүдээ намын удирдах байгууллага, албан тушаал, сонгуульд нэр дэвших, сонгох, томилоход аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байж, тэгш боломж олгоно”, 8.3-т “Энэ хуулийн 16.1-д заасан байгууллагын болон намын бусад хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэх, цөөнхийн саналыг хэлэлцэх боломж олгож хүндэтгэн үзэх ...” гэж заасан ба Либертари нам (ЛН)-ын үүсгэн байгуулах Их хурлын хуралдааны явцад нэр дэвшигчид намын даргыг сонгох сонгуульд өөрсдийн нэрийг чөлөөтэй дэвшүүлэн оролцсон, тус санал хураалтад оролцсон намын гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэсэн зэргээр санал хураалт хуулийн үндсэн зарчимд нийцсэн байх ба намын даргын мэдээлэл, холбогдох баримтыг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 12 дугаар зүйлийн 12.3.7-д нийцүүлэн ирүүлсэн байх тул намын даргаар Э.Оргил-Эрдэнэ сонгогдсоныг бүртгэх нь зүйтэй гэж үзлээ.

Дээрхээс дүгнэхэд, Либертари нам (ЛН)-ын үзэл баримтлал, зорилго, үнэт зүйл болон үйл ажиллагааны зарчим нь Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.2-т заасныг зөрчөөгүй, намыг үүсгэн байгуулах Их хурлыг хуульд заасан хугацааны шаардлагад нийцүүлэн гишүүдийн болон орон нутгийн төлөөлөгчдийн оролцоог ханган хуралдуулж, мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4-т заасан үүсгэн байгуулах Их хурлаар хэлэлцэн шийдвэрлэхээр заасан асуудлыг бүрэн хэлэлцэн шийдвэрлэсэн байх ба намын үндсэн дүрэм нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд харшилсан агуулгагүй, намын үндсэн дүрэмд Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 15 дугаар зүйлийн 15.2-т зааснаар тусгавал зохих зүйлийг бүрэн тусгасан байна.

Иймд, Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 14 дүгээр зүйлийн 14.4-т заасан намыг бүртгэхээс татгалзах үндэслэл тогтоогдоогүй тул Либертари нам (ЛН)-ыг шинээр үүсгэн байгуулагдсан болон намын даргыг бүртгэх үндэслэлтэй гэж Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас дүгнэв.

Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2, 14.8-д заасныг баримтлан Либертари нам (ЛН) үүсгэн байгуулагдсаныг улс төрийн намын бүртгэлд бүртгэсүгэй.

2.Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 15 дугаар зүйлийн 15.5, 17 дугаар зүйлийн 17.6-д заасныг баримтлан намын даргаар Эрдэнэбатын Оргил-Эрдэнийг бүртгэсүгэй.

3.Либертари нам (ЛН) нь улс төрийн намын бүртгэлд бүртгүүлснээр Монгол Улсын нутаг дэвсгэрт улс төрийн үйл ажиллагаа явуулах эрхтэй болсныг дурдсугай.

4.Монгол Улсын Үндсэн хууль, Улс төрийн намын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг дээдлэн сахиж ажиллахыг Либертари нам (ЛН)-д даалгасугай.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

П.СОЁЛ-ЭРДЭНЭ